

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

Б А Р У У Н Т У Р У У Н С У М Ы Н
З А С А Г Д А Р Г Ы Н Т А М Г Ы Н Г А З Р Ы Н
Д А Р Г Ы Н ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНХБАЯР ТАНАА

2022.02.15 № УВА-2022/62/НА-СТА-ТЧУЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000387

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	3
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,912,559.00	56,102,225.00
33	АВЛАГА	470,000.00	720,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	470,000.00	720,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,442,559.00	55,382,225.00
35400	Хангамжийн материал	48,442,559.00	47,387,559.00
35410	Бичиг хэргийн материал	973,000.00	973,000.00
35420	Аж ахуйн материал	34,695,559.00	33,640,559.00
35470	Бусад хангамжийн материал	12,774,000.00	12,774,000.00
35600	Мал амьтад	0.00	7,994,666.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	780,484,024.15	991,795,478.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	780,484,024.15	991,795,478.76
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	767,743,324.11	804,809,178.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	736,766,017.66	785,760,817.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-257,695,329.51	-316,085,862.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,919,500.00	239,519,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-85,448,426.79	-123,603,993.70
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	359,827,587.40	376,226,272.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-267,843,723.01	-293,549,348.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,145,435.77	63,745,435.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,490,675.91	-27,509,384.47
39209	Зам, гүүрийн байгууламж	84,673,096.00	84,673,096.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-48,686,323.96	-54,933,633.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	300,079,404.50	317,651,304.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-235,503,238.04	-247,085,024.16
39300	Биет бус хөрөнгө	12,740,700.04	186,986,300.04
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-915,499.96	-981,499.96
39303	Бусад биет бус хөрөнгө	13,351,200.00	187,662,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	829,396,583.15	1,047,897,703.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	350,000.00	1,696,542.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	350,000.00	1,696,542.29
41300	Өглөг	350,000.00	1,696,542.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	350,000.00	1,696,542.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	829,046,583.15	1,046,201,161.47
51	Засгийн газрын хувь оролцоо	829,046,583.15	1,046,201,161.47
51100	Засгийн газрын оруулсан капитал	443,487,232.35	443,487,232.35
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	443,487,232.35	443,487,232.35
51200	Хуримтлагдсан үр дүн	65,263,732.53	282,418,310.85
51210	Өмнөх үеийн үр дүн	139,925,609.36	65,263,732.53
51220	Тайлант үеийн үр дүн	-74,661,876.83	217,154,578.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	320,295,618.27	320,295,618.27

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	829,396,583.15	1,047,897,703.76
---	--	-----------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	454,714,509.00	745,057,551.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,680,520.00	354,151,651.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,680,520.00	354,151,651.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,680,520.00	354,151,651.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	71,680,520.00	354,151,651.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	383,033,989.00	390,905,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,744,189.00	9,420,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,160,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,750,000.00	8,920,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,834,189.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,289,800.00	381,485,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,289,800.00	381,485,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	527,396,285.99	527,902,972.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,396,285.99	527,902,972.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,095,665.32	517,224,522.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,253,736.37	251,145,062.29
210101	Үндсэн цалин	214,730,947.48	189,845,172.68
210102	Нэмэгдэл	0.00	33,910,054.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	0.00	8,184,574.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,522,788.89	19,205,261.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,874,955.49	30,399,108.26
210201	Тэтгэврийн даатгал	22,392,101.65	20,783,102.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,529,191.27	2,483,351.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,979,647.89	1,986,680.95
210204	Ажилгүйдлийн даатгал	495,209.72	463,673.81
210205	Эрүүл мэндийн даатгал	4,478,804.96	4,682,299.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,282,685.00	31,298,937.00
210301	Гэрэл, цахилгаан	4,308,399.00	5,718,585.00
210302	Түлш, халаалт	30,974,286.00	25,580,352.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00

210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,534,328.00	37,061,290.00
210401	Бичиг хэрэг	2,896,390.00	1,406,690.00
210402	Тээвэр, шатахуун	18,333,058.00	30,643,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,134,020.00	2,942,700.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,008,660.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,162,200.00	1,618,400.00
2105	Нормативт зардал	883,600.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	883,600.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,402,800.00	3,472,000.00
210604	Урсгал засвар	4,402,800.00	3,472,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,126,000.00	2,991,200.00
210702	Дотоод албан томилолт	4,126,000.00	2,991,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,972,761.00	1,110,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	853,000.00	213,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,474.00	84,975.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,975.00	131,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	0.00
210807	Газрын төлбөр	85,112.00	78,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,764,799.46	159,646,030.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,675,121.00	14,064,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	235,280.00	416,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,854,398.46	145,165,530.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,300,620.67	10,678,449.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,464,400.00	9,851,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	8,368,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	811,000.00	1,483,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,836,220.67	826,749.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,562,220.67	826,749.74

213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,274,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-72,681,776.99	217,154,578.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-72,681,776.99	217,154,578.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	383,033,989.00	390,905,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	383,033,989.00	390,905,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,744,189.00	9,420,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,160,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,750,000.00	8,920,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,834,189.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,289,800.00	381,485,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,289,800.00	381,485,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382,933,989.00	380,585,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,933,989.00	380,585,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,618,368.33	369,657,450.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,834,237.84	249,858,500.00
210101	Үндсэн цалин	217,563,300.94	189,433,923.35
210102	Нэмэгдэл	0.00	33,317,321.75
210104	Урамшуулал	0.00	8,154,095.88
210105	Гэрээт ажлын хөлс	28,270,936.90	18,953,159.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,874,955.49	30,589,128.26
210201	Тэтгэврийн даатгал	22,432,001.60	21,009,122.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,489,291.32	2,474,351.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,979,647.89	1,979,480.95
210204	Ажилгүйдлийн даатгал	456,352.53	461,873.81
210205	Эрүүл мэндийн даатгал	4,517,662.15	4,664,299.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,282,685.00	35,698,937.00
210301	Гэрэл, цахилгаан	4,308,399.00	5,718,585.00
210302	Түлш, халаалт	30,974,286.00	29,980,352.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,084,840.00	26,028,190.00
210401	Бичиг хэрэг	2,815,070.00	1,397,690.00
210402	Тээвэр, шатахуун	15,450,400.00	20,650,400.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,334,020.00	2,942,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	928,150.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,557,200.00	37,400.00
2105	Нормативт зардал	512,300.00	512,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	512,300.00	512,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,147,500.00	3,738,000.00
210604	Урсгал засвар	4,147,500.00	3,738,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,126,000.00	2,991,200.00
210702	Дотоод албан томилолт	4,126,000.00	2,991,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,411,061.00	1,154,695.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	291,300.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,474.00	105,475.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,975.00	110,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	0.00
210807	Газрын төлбөр	85,112.00	78,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,344,789.00	19,086,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,034,989.00	18,670,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	309,800.00	416,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,315,620.67	10,928,449.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,479,400.00	10,101,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	8,368,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	826,000.00	1,733,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,836,220.67	826,749.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,562,220.67	826,749.74
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,274,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	100,000.00	10,320,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	100,000.00	10,320,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000.00	10,320,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	100,000.00	10,320,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	100,000.00	10,320,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-100,000.00	-10,320,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,962,432.35	320,295,618.27	113,644,225.27	873,902,275.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,962,432.35	320,295,618.27	113,644,225.27	873,902,275.89
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-72,681,776.99	-72,681,776.99
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	443,487,232.35	320,295,618.27	65,263,732.53	829,046,583.15
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	443,487,232.35	320,295,618.27	65,263,732.53	829,046,583.15
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	443,487,232.35	320,295,618.27	65,263,732.53	829,046,583.15
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	217,154,578.32	217,154,578.32
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	443,487,232.35	320,295,618.27	282,418,310.85	1,046,201,161.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,485,900.00	380,659,150.26	826,749.74	99.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,485,900.00	380,659,150.26	826,749.74	99.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,284,200.00	371,457,450.26	826,749.74	99.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,858,500.00	249,858,500.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	229,698,500.00	189,433,923.35	40,264,576.65	82.47
210102	Нэмэгдэл	0	33,317,321.75	-33,317,321.75	#DIV/0!
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0	0.00	#DIV/0!
210104	Урамшуулал	0	8,154,095.88	-8,154,095.88	#DIV/0!
210105	Гэрээт ажлын хөлс	20,160,000.00	18,953,159.02	1,206,840.98	94.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,232,300.00	30,589,128.26	643,171.74	97.94
210201	Тэтгэврийн даатгал	21,238,000.00	21,009,122.88	228,877.12	98.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,498,700.00	2,474,351.07	24,348.93	99.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,998,800.00	1,979,480.95	19,319.05	99.03
210204	Ажилгүйдлийн даатгал	499,700.00	461,873.81	37,826.19	92.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,997,100.00	4,664,299.55	332,800.45	93.34

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,792,900.00	35,698,937.00	93,963.00	99.74
210301	Гэрэл, цахилгаан	4,257,300.00	5,718,585.00	-1,461,285.00	134.32
210302	Түлш, халаалт	31,535,600.00	29,980,352.00	1,555,248.00	95.07
210303	Цэвэр, бохир ус	0	0	0.00	#DIV/0!
210304	Байрны түрээс	0	0	0.00	#DIV/0!
2104	Хангамж, бараа материалын зардал	20,158,500.00	20,148,190.00	10,310.00	99.95
210401	Бичиг хэрэг	1,408,000.00	1,397,690.00	10,310.00	99.27
210402	Тээвэр, шатахуун	14,650,400.00	14,650,400.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,942,700.00	2,942,700.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	0	0	0.00	#DIV/0!
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	157,400.00	157,400.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	512,300.00	512,300.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0	0.00	#DIV/0!
210502	Хоол, хүнс	0	0	0.00	#DIV/0!
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	512,300.00	512,300.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,357,000.00	5,338,000.00	19,000.00	99.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210602	Тавилга	0	0	0.00	#DIV/0!
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0	0.00	#DIV/0!
210604	Урсгал засвар	4,157,000.00	4,138,000.00	19,000.00	99.54
2107	Томилолт, зочны зардал	2,991,200.00	2,991,200.00	0.00	100.00
210701	Гадаад албан томилолт	0	0	0.00	#DIV/0!
210702	Дотоод албан томилолт	2,991,200.00	2,991,200.00	0.00	100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0	0.00	#DIV/0!
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,215,000.00	1,154,695.00	60,305.00	95.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,000.00	105,475.00	39,525.00	72.74
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	110,500.00	9,500.00	92.08
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	0	0.00	#DIV/0!
210807	Газрын төлбөр	90,000.00	78,720.00	11,280.00	87.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,166,500.00	25,166,500.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,750,000.00	24,750,000.00	0.00	100.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	416,500.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,201,700.00	9,201,700.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,201,700.00	9,201,700.00	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368,700.00	8,368,700.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	833,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	381,485,900.00	381,485,900.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0.00	#DIV/0!
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	#DIV/0!
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	381,485,900.00	381,485,900.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	381,485,900.00	381,485,900.00	0.00	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0.00	#DIV/0!
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	7	7	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	6	6	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	4	4	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0.00	100.00

2.5 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,420,000.00	9,420,000.00
	УРСГАЛ ЗАРДАЛ		9,420,000.00	9,420,000.00
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,520,000.00	8,520,000.00
	Хангамж, бараа материалын зардал		6,000,000.00	6,000,000.00
	Тээвэр, шатахуун		6,000,000.00	6,000,000.00
	Бараа үйлчилгээний бусад		2,520,000.00	2,520,000.00
	Бараа үйлчилгээний бусад		2,520,000.00	2,520,000.00
	Урсгал шилжүүлэг		900,000.00	900,000.00
	Бусад урсгал шилжүүлэг		900,000.00	900,000.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		900,000.00	900,000.00
	Зардал санхүүжүүлэх эх үүсвэр		9,420,000.00	9,420,000.00

	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,420,000.00	9,420,000.00
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,920,000.00	8,920,000.00
	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		500,000.00	500,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын ЗДТГ нь төрийн захиргааны байгууллага бөгөөд түүнд тайлагнадаг гүйцэтгэх удирдлагаар уламжлан нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг холбогдох хуулийн хүрээнд зохицуулдаг байгууллага юм.

Ардчиллыг бэхжүүлж, төрийн захиргааны манлайллыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэх, тэдний нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах зорилготой байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд дотооддоо сумын ИТХ болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд ААН-үүд, гадаад талдаа дээд шатны байгууллага, яам агентлаг, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас гарсан шийдвэр, үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, зохион байгуулах зэргээр ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 218,501.1 сая төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн байна. Энэ өсөлт нь тус байгууллага үндсэн хөрөнгөд газар бүртгэж авсан болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэсэн зэргээс голлон шалтгаалжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	470.00	720.00	250.00
Бараа материал	48,442.6	55,382.2	6,939.6
Үндсэн хөрөнгө	780,484.0	991,795.5	211,311.5
Нийт хөрөнгө	829,396.6	1,047,897.7	218,501.1
Өр төлбөр	350.0	1,696.5	1,346.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	829,046.6	1,046,201.2	217,154.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	829,396.6	1,047,897.7	218,501.1

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 720.0 мянган төгрөг болж 250.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой авлаг өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 55,382.2 мянган төгрөг болж 6,939.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад байгууллагаас хандиваар мал амьтад авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 991,795.5 мянган төгрөг болж 211,311.5 мянган төгрөгөөр өссөнд Үйлдвэрлэл, элеватор барих газар дансанд бүртгэж авсан, багийн төвийн үнсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлсэн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэсэн зэргээс голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 10,320.0 мянган төгрөгөөр тоног, төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, 346,156.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан болон систем хоорондын тооцоогоор шилжүүлэн авснаар нэмэгдэж, 145,165.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,696.5 мянган төгрөг болж 1,346.5 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,046,201.2 мянган төгрөг болж 217,154.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 462,430.4 мянган төгрөг, нийт зарлагыг 462,460.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 30,447.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,613.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 8,489.2 мянган төгрөгөөр гэх мэт зарим зардлыг танаж, 376,485.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ковидын дараах улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 376,485.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг урд оны давсан орлогоос бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 376,485.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, давсан орлогоос 5,000.0 сая төгрөгийг нэмж хуваарилж, нийт 381,485.9 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 380,659.1 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна. Үндсэн данснаас 826.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	221,637.5	230,230.75	8,593.2	102.3
2	Баг хорооны Ү/а зардал	63,371.3	63,371.3	0	100

3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	38,549.9	38,549.9	0	100
4	Нийтлэг үйлчилгээ	31,675.5	31,675.5	0	100
5	Мэдээлэл сурталчилгааны зардал	250.0	250.0	0	100
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж	833.0	833.0	0	100
7	Сонгуулийн дүнгээр чөлөөлөгдсөн	8,368.7	8,368.7	0	100
8	Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.0	10,000.0	0	100
9	Хур хог хаягдал орчны бохирдол	1,000.0	1,000.0	0	100
10	Ахмад настны хөгжил хамгаалал	600.0	600.0	0	100
11	Улсын их баяр наадам	4,000.0	4,000.0	0	100
12	Мал тооллого	1,200.0	1,200.0	0	100
	Дүн	381,485.9	390,079.1	8,593.2	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8,920.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 500.0 мянга, нийт 9,420.0 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс Тээвэр шатахууны зардал 6,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,520.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 900.0 мянга, нийт 9420.0 мянган төгрөг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,273.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 527,902.9 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 5,279.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,223.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 1, хугацаандаа 148 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 6,036.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 181.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “Гар утасны зардал” гэж заасныг зөрчин Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 181.5 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөнд буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөн байна	1	181.5	1	181.5								
Дүн	1	181.5	1	181.5								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Т.НАМЖИЛ/

2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01/02/А2060412
УБА-2023/02/НА-СГА ТУС

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 181.5 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “Гар утасны зардал” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан гар утасны нэгжийн үнэ 181 500 /нэг зуун наян нэгэн мянга таван зуу/ төгрөгийг төрд хохирол учруулсан буруутай албан тушаалтнаар төлүүлж Орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Анхбаяр, нягтлан бодогч С.Элдэвсайхан нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ



**ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Баруунтуруун сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2023/62/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	---	-------------------	-----------------------------

1.5 Төлбөрийн актын дугаар		1.6 Огноо	2023.02.14	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	181,500
----------------------------	--	-----------	------------	----------------------------	---------

1.8 Төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 181.5 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөн байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, хэмнэлтийн тухай хууль		
		Заалт	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “Гар утасны зардал”		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8 дахь заалт			

		Заалт	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”
--	--	-------	---

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	181,500	
	Тухайн байгууллагын дансанд		
	Зөрчил арилгах		2022.03.30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Төлбөрийн хүсэлт	№179	2022.12.02	Дэвжих туруун ХХК-д
2	И-баримт		2022.11.29	Дэвжих туруун ХХК-д
3	Зарлагын баримт	№	2022.11.29	Дэвжих туруун ХХК-д
4	Олгосон жагсаалт		2022.12.22	Ажилтнуудын нэрсийн жагсаалт гарын үсэгтэй

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл


№	Аудитын багийн		Хариуцагч			
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Ахлах аудитор	Т.Намжил	Баруунтуруун сумын ЗДТГ	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Анхбаяр	88556818
				Нягтлан бодогч	С.Элдэвсайхан	88556818

Төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	2023.02.15	—	
2	Дарга, тэргүүлэх аудитор	2023.02.15	—	

4.2 Төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2023.02.15	

2. Төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо	2023.02.25	
		Дугаар	
2	Төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2023.02.25	
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Баруунтуруун сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	С.Элдэвсайхан
			Албан тушаал	Нягтлан бодогч
4	Төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Баруунтуруун сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	Д.Анхбаяр
			Албан тушаал	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	1
			Дүн	181,000
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ
 Байгууллагын нэр: Баруунтуруун сумын ЗДТГ
 Тайланг хугацаа: 2022.01.01-2022.12.31

№	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан ~тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10
1	2022 оны Санхүүгийн тайлангийн аудит	Шуудан холбооны зардлаас байгууллагын ажилтнуудад 181.5 мянган төгрөгийн гар утгасны нэгж худалдан авч өгсөн байна.	181,500			хариу тайлбар байхгүй	Төлбөрийн акт	Баруунтуруун сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Анхбаяр

Бэлтгэсэн:
 Ахлах аудитор
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг



Т.Намжил
 Огноо: 2023.02.13

Анхан шатанд хянасан:
 Аудитын менежер




М.Бат-Амгалан
 Огноо: 2023.02.13

Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Огноо: 2023.02.13

Хоёр дахь шатанд хянасан:
 Дарга, тэргүүлэх аудитор
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Танилцаж зөвшөөрсөн:
 Нягтлан бодогч
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг



С.Эгдэвсайхан
 Огноо: 2023.02.13

Танилцаж зөвшөөрсөн:
 Баруунтуруун сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Анхбаяр

Огноо: 2023.02.13